



ДОРНОГОВЬ АЙМАГ  
“ЧАНДМАНЬ-ИЛГЧ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 01

Сайншанд сум

Журам батлах тухай

Монгол Улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалт, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6.4 дэх заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгалийн онц аюултай үзэгдэл, нийтийг хамарсан цочмог хурц өвчлөл, ноцтой хэлбэрийн аюултай тохиолдол гарах үед удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор "Онцгой байдалд хариу арга хэмжээ авах журам"-ыг 01 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа мөрдлөг болгож, хэрэгжилтийг хангаж ажиллахыг нийт хэлтэс, алба, салбарын дарга нарт даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер (Х.Бариадбаасанжав)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГ

Д.ЭРДЭНЭБАЯР



4432'9279

Захирлын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн  
А/29 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



## ОНЦГОЙ БАЙДАЛД ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЖУРАМ

### НЭГ. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журмын зорилго нь байгалийн онц аюултай (салхи, шуурга, хэт халуун ба хүйтрэлт) үзэгдэл, нийтийг хамарсан цочмог хурц өвчлөл, осол гэх мэт ноцтой хэлбэрийн аюултай тохиолдол (цаашид "Гамшиг" гэх) гарах үед зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагааны хүрээнд компанийн нийт ажилтнууд эдлэх эрх, хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### ХОЁР. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

2.1. Журмын биелэлтэнд үйлдвэрийн удирдлага болон хэлтэс, хэсэг, салбар (цаашид "Нэгж" гэх) -ын удирдлагууд хяналт тавьж ажиллана.

2.2. Энэхүү журамд заасан дараах томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.2.1. "**Гамшигаас хамгаалах**" гэж гамшигийн аюулаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд учирсан хор уршигийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох, эдгээр үйл ажиллагаанд ажилтнуудыг сургах бэлтгэх, цогцолбор арга хэмжээ;

2.2.2. "**Урьдчилан сэргийлэх**" гэж гамшигийн аюул, болзошгүй хохиролыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг;

2.2.3. "**Онцгой байдал**" гэж байгалийн онц аюултай (салхи, шуурга, хэт халуун ба хүйтрэлт) үзэгдэл, нийтийг хамарсан хурц цочмог өвчлөл, осол болон ноцтой хэлбэрийн аюултай нөхцөл байдлыг;

2.2.4. "**Аврах ажиллагаа**" гэж гамшигийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрж хайх, аврах, гал түймэрийн шаталтыг зогсоох, унтраах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, гамшигийн голомтоос гаргах, хор уршгийг арилгах үйл ажиллагааг хэлнэ.

### ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. Энэхүү журам нь гамшиг, аюултай тохиолдлоос урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгоход компанийн удирдлага, Гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, нэгжийн ажилтнууд нь нийт ажилтнуудыг үйл ажиллагааны мэргэжлийн удирдлагаар хангах, уялдуулан зохион байгуулах, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд үйлчилнэ.

### ДӨРӨВ. ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДАЛ ТОХИОЛДСОН ҮЕД АЖИЛЛАХ ШУУРХАЙ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гамшиг, онцгой тохиолдолын үед ажиллах шуурхай бүрэлдэхүүн нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

4.1.1. Шуурхай бүрэлдэхүүний дарга: *Үйлдвэрийн захирал, эсвэл түүнийг орлон ажиллах хүн*

4.1.2. Гишүүн: *ХАБЭА-н асуудал хариуцсан удирдах албан тушаалтан*

4.1.3. Гишүүн: *ХАБЭА-н асуудал хариуцсан ИТА*



4.1.4.Гишүүн: *Хэлтэс, хэсэг, салбарын удирдлага*

4.1.5.Гишүүн: *Яаралтай түргэн тусламжийн бүрэлдэхүүн*

4.1.6.Гишүүн: *Гамшигаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн*

4.2.Шуурхай бүрэлдэхүүний дарга нь шуурхай бүрэлдэхүүнийг дуудах, татан оролцуулах, дайчлах эрхтэй.

4.3.Шуурхай бүрэлдэхүүний дарга шаардлагатай тохиолдолд ажлын удирдагч томилон үүрэг, чиглэл өгч ажиллана.

4.4.Томилогдсон ажил удирдагч нь ажиллах хүмүүстээ ажлын байрыг нь зааж, шуурхай бүрэлдэхүүний даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар тодорхой удирдамж чиглэл болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажлыг аюул осолгүй зохион байгуулна.

4.5.Гамшиг, онцгой аюултай байдлын үед машин техник, хүн хүч шаардлагатай зүйлийг гаргах, томилох, зарцуулах эрхтэй.

4.6.Хүмүүсийг аврах, өөрсдийн хүч бололцоо хүрэхээргүй нөхцөл байдал бий болсон тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай мэдэгдэн хамтран ажиллана.

4.7.Шуурхай бүрэлдэхүүний дарга нь дараах үүргийг хүлээнэ.

4.7.1.Энэхүү бодлогод нийцүүлэн ажиллана.

4.7.2.Хэрэгжилтэнд байнга хяналт тавьж ажиллана.

4.7.3.Хариу арга хэмжээ авах сургалтыг жилд 1 удаа зохион байгуулна.

4.7.4.Энэхүү журмыг гамшиг, онцгой байдлын үед ажиллах ажилтнууд нь бүрэн нягталж ойлгож байгаа эсэхэд хяналт тавина.

#### **ТАВ. ГАМШИГ, ОНЦГОЙ (БАЙГАЛИЙН ОНЦ АЮУЛТАЙ ҮЗЭГДЭЛ, САЛХИ ШУУРГА) БАЙДАЛ ТОХИОЛДСОН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЗАРЧИМ**

5.1.Гамшиг, онцгой байдлын үед чухал зэрэглэлд доорх дарааллыг үзнэ.

5.1.1.Хүн (ажилтан)

5.1.2.Үйлдвэрлэлийн өмч хөрөнгө

5.1.3.Байгаль

5.2.Дээрх арга хэмжээнүүдийг доорх хэсгүүдэд илүү чухалчлан авч хэрэгжүүлнэ.

5.2.1.Дулааны станцын байгууламж, түүний нийт дамжлагууд

5.2.2.Цахилгаан хувиарлах байгууламж, тоноглол

5.2.3.Цэвэрлэх байгууламж, түүний нийт дамжлагууд

5.2.4.Инженерийн шугам сүлжээ

5.2.5.Нүүрс буулгах, хадгалах талбай

5.2.6.Ус шинжилгээний лаборатори

5.2.7.Авто машин техник, механизмын гражж

5.2.8.Дизель цахилгаан үүсгүүр

5.2.9.Шатахуун хадгалах, зөөх, тээвэрлэх машин механизм болон агуулах

5.2.10.Үйлдвэрлэлийн нийт хэлтэс, алба, салбарууд

5.3.Гамшиг, онцгой байдлын дуудлага авсан ажилтан тухайн үүссэн нөхцөл, байдлын талаар цаг алдалгүй хяналтын хэлтэст мэдэгдэнэ.

5.4.Мэдээллийн дагуу шуурхай бүрэлдэхүүнийг цуглах цэгт дуудаж гамшиг болон байгалийн онц аюултай тухайн тохиолдолд тохирсон шуурхай төлөвлөгөөний дагуу ажил үүргийн хуваарилалтыг хийнэ.

5.5.Ажил үүрэг авсан ажилтнууд ажлын эхлэл, явц, нөхцөл байдлын талаар шууд удирдлага болон шуурхай бүрэлдэхүүний даргад байнга мэдээлж ажиллахаас гадна онцгой байдлын онцлогоос хамаарч сэргээн босгох хэвийн болгох үйл ажиллагааг бүрэн хариуцна.

5.6.Үүссэн гамшиг, онцгой байдлын байдлыг тодорхойлж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар компанийн удирдлага, төр захиргааны холбогдох байгууллагад шуурхай мэдээлнэ.

5.7.Шугам хоолой, үзлэгийн худаг, суваг, барилга байгууламжид нарийвчилсан үзлэг хийж, гэмтэл гарсан тохиолдолд байгууллагын удирдлагад мэдэгдэж, гэмтлийг богино хугацаанд арилгах арга хэмжээ авахын хамт шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн схемд зохих өөрчлөлтийг аваарын горимын дагуу оруулж хэвийн ажиллагааг хангана.

5.8.Дулааны эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг аль болох тасалдуулахгүй байх боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ**

6.1.Шуурхай бүрэлдэхүүн нь гамшиг, онцгой байдлаас хамгаалах бэлэн байдлын (цаашид "бэлэн байдал" гэх) дараах зэрэгтэй байна.

6.1.1. Өдөр тутмын бэлэн байдал

6.1.2. Өндөржүүлсэн бэлэн байдал

6.2.Өдөр тутмын бэлэн байдлын үед шуурхай бүрэлдэхүүн нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.1.Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу ажил үүргийн хуваарилалт хийнэ.

6.2.2.Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай хүн хүч, техник, материал, хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ.

6.2.3.Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах талаар сургалт, бэлтгэлийг зохион байгуулна.

6.2.4.Гамшиг, онцгой байдлын аюул үүссэн буюу үүсч болзошгүй байдалтай холбогдуулан төрийн болон нутгийн захиргаа, Онцгой байдлын ерөнхий газарт мэдээлнэ.

6.3.Өндөржүүлсэн бэлэн байдлын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.1.Зарлан мэдээллэх дохиог нийт ажилтнуудад хүргэх, гамшиг, онцгой байдалд хариу авах арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

6.3.2.Харилцаа холбоо, мэдээлэл хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгана.

6.3.3.Шаардлагатай тохиолдолд харъяаллын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга болон төрийн захиргааны байгууллагаас тусламж авах талаар мэдэгдэнэ.

6.4.Хүн хүч, техник, материал, хэрэгслийг дайчлан гаргах ажлыг зохион байгуулах зорилгоор сургалт зохион байгуулна. Үүнд:

6.4.1.Гамшигаас хамгаалах сургалтын зорилго нь гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох, үйл ажиллагаанд компанийн нийт ажилтнуудыг сургаж дадлагажуулна.

6.4.2.Гамшигаас хамгаалах сургалтыг компанийн хэлтэс, хэсэг, салбарууд, гэрээлэгч компани, сонирхогч талуудын хүрээнд жил бүр зохион байгуулна.

5.5. Ажил үүрэг авсан ажилтнууд ажлын эхлэл, явц, нөхцөл байдлын талаар шууд удирдлага болон шуурхай бүрэлдэхүүний даргад байнга мэдээлж ажиллахаас гадна онцгой байдлын онцлогоос хамаарч сэргээн босгох хэвийн болгох үйл ажиллагааг бүрэн хариуцна.

5.6. Үүссэн гамшиг, онцгой байдлын байдлыг тодорхойлж, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар компанийн удирдлага, төр захиргааны холбогдох байгууллагад шуурхай мэдээлнэ.

5.7. Шугам хоолой, үзлэгийн худаг, суваг, барилга байгууламжид нарийвчилсан үзлэг хийж, гэмтэл гарсан тохиолдолд байгууллагын удирдлагад мэдэгдэж, гэмтлийг богино хугацаанд арилгах арга хэмжээ авахын хамт шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн схемд зохих өөрчлөлтийг аваарын горимын дагуу оруулж хэвийн ажиллагааг хангана.

5.8. Дулааны эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг аль болох тасалдуулахгүй байх боломжтой бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. ГАМШИГ, ОНЦГОЙ БАЙДЛААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ**

6.1. Шуурхай бүрэлдэхүүн нь гамшиг, онцгой байдлаас хамгаалах бэлэн байдлын (цаашид "бэлэн байдал" гэх) дараах зэрэгтэй байна.

6.1.1. Өдөр тутмын бэлэн байдал

6.1.2. Өндөржүүлсэн бэлэн байдал

6.2. Өдөр тутмын бэлэн байдлын үед шуурхай бүрэлдэхүүн нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.1. Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний дагуу ажил үүргийн хуваарилалт хийнэ.

6.2.2. Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай хүн хүч, техник, материал, хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ.

6.2.3. Гамшиг, онцгой байдалд хариу арга хэмжээ авах талаар сургалт, бэлтгэлийг зохион байгуулна.

6.2.4. Гамшиг, онцгой байдлын аюул үүссэн буюу үүсч болзошгүй байдалтай холбогдуулан төрийн болон нутгийн захиргаа, Онцгой байдлын ерөнхий газарт мэдээлнэ.

6.3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.1. Зарлан мэдээллэх дохиог нийт ажилтнуудад хүргэх, гамшиг, онцгой байдалд хариу авах арга хэмжээний төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

6.3.2. Харилцаа холбоо, мэдээлэл хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгана.

6.3.3. Шаардлагатай тохиолдолд харъяаллын дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга болон төрийн захиргааны байгууллагаас тусламж авах талаар мэдэгдэнэ.

6.4. Хүн хүч, техник, материал, хэрэгслийг дайчлан гаргах ажлыг зохион байгуулах зорилгоор сургалт зохион байгуулна. Үүнд:

6.4.1. Гамшигаас хамгаалах сургалтын зорилго нь гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох, үйл ажиллагаанд компанийн нийт ажилтнуудыг сургаж дадлагажуулна.

6.4.2. Гамшигаас хамгаалах сургалтыг компанийн хэлтэс, хэсэг, салбарууд, гэрээлэгч компани, сонирхогч талуудын хүрээнд жил бүр зохион байгуулна.

## **ДОЛОО. БАЙГАЛИЙН ОНЦ АЮУЛТАЙ ҮЗЭГДЭЛ, САЛХИ ШУУРГА, БУСАД ГАМШИГИЙН ҮЕД СЭРГЭЭН БОСГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

7.1.Яаралтай түргэн тусламж, галын машин, шуурхай бүрэлдэхүүний автомашинууд нь онцгой, нөхцөл байдал үүссэн газарт очихдоо зөвшөөрөл авах шаардлагагүй.

7.2.Гамшиг, онцгой байдал бий болсон үед учирсан болон цаашид учирч болзошгүй хохирлын хэмжээ, үр дагавар, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнгийн талаар төрийн захиргааны холбогдох байгууллагад цаг алдалгүй мэдээлэх.

7.3.Аврах, хор уршигийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулахад удирдлагаар хангах үүрэг бүхий шуурхай бүрэлдэхүүнийг томилон ажиллуулах.

7.4.Аврах, хор уршигийг арилгах, сэргээн босгох гэж байгаа ажлын байр, тоног төхөөрөмж, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг сайтар шалгах.

7.5.Тухайн сэргээн босгох ажлыг аюул осолгүй гүйцэтгэх бүх боломжит арга хэмжээг авах.

7.6.Аврах, хор уршигийг арилгах, сэргээн босгох ажилд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гаргах, материал, техник, багаж хэрэгслийг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авах.

7.7.Ажил хийх явцад үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл, хүндрэл үүссэн тохиолдолд хүмүүсээ ажлын байрнаас цаг алдалгүй холдуулж, аюулгүйн зайд байрлуулах.

7.8.Аж ахуйн нэгжийг бүхэлд нь буюу зарим хэсгийг онцгой дэглэмд шилжүүлэх, ажилтнуудыг уртасгасан цагаар ажиллуулах.

7.9.Хүмүүсийг аврах, анхны тусламж үзүүлэхдээ цаг алдалгүй түргэн шуурхай зөв гүйцэтгэх.

### **НАЙМ. ОНЦ БҮСЭД НЭВТРЭХ**

8.1.Үзлэг шалгалт хийх төлөөлөл нь үйлдвэрийн онцгой объектуудад нэвтрэх эрхтэй ба тухайн хэлтсийн удирдлагуудад мэдэгдэх.

8.2.Тухайн объектод очиж хариуцлагатай ажилтанд ирсэн тухайгаа мэдэгдэж онцгой объектод ажиллах тусгай заавар авна.

8.3.Уг онцгой объектын тусгай зааварт хориглох зүйлс (гар утас, радио станц, асаагуур, тамхи) бусад шаардлагагүй эд материалуудыг оруулахыг хориглоно.

8.4.Онцгой объектод нэвтрэхдээ ХАБЭА хариуцсан ИТА 1-2 хүн орох ба заавал тухайн хэлтэс, хэсэг, салбарын инженер техникийн ажилтантай үзлэг шалгалтыг хамтарч хийх.

### **ЕС. ХАРИУЦЛАГА**

9.1.Гамшиг, онцгой байдлын шуурхай ажиллагаанд дуудсан цагт ирээгүй, ирсэн үедээ аюулгүй ажиллагаа, холбогдох дүрэм журмыг зөрчсөн ажилтанд Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## **ХАМГИЙН ТҮРҮҮНД АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**